

**НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН ДАРГЫН  
ХАРИУЦЛАГЫН ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТ**

2021 оны 12 дугаар сарын 14-ний өдөр

Улаанбаатар хот

№	ГЭРЭЭНИЙ ЗААЛТ	ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТ
1	1	3
2	<p>3.2.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлд тусгагдсан өөрийн байгууллагын чиг үүрэгт хамаарах зорилтын хэрэгжилтийг хангаж, холбогдох журамд заасан хугацаанд тайлагнана.</p>	<p>Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтэд 2021 оны эхний хагас жилээр Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгэж, 2021 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 2/629 дүгээр албан бичгээр, 03 дугаар улирлын биелэлтийг 2021 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн 2/1792 дугаар албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст хүргүүлсэн. Жилийн эцсийн биелэлтийг 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр хүргүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.</p> <p>Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлд тусгагдсан өөрийн байгууллагын чиг үүрэгт хамаарах 1 зорилтын 2 арга хэмжээний хэрэгжилтийг нэгтгэн 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдөр хүргүүлэв.</p>
3	<p>3.3.Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд төсөв, санхүүгийн сахилга батыг чанд мөрдөж, төсвийн зардлыг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулж, байгууллагын өмч, хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаарх аливаа гэрээний биелэлт, гүйцэтгэл үр дүнг Нийслэлийн Засаг даргын өмнө хариуцаж ажиллах.</p>	<p>"Нийслэлийн хотын шуудын 2021 оны төсвийн хуваарь"-ийн дагуу 2021 оны 01-12 дугаар сард төсвөөс санхүүжих урсгал зардлын санхүүжилт 785,2 сая төгрөг төлөвлөсөн төсвийн гүйцэтгэлээр 700,4 сая төгрөгийн зардлын гүйцэтгэлтэй 84,8 сая төгрөгийн хэмнэлттэй ажилласан байна. Монгол улсын Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг хангаж ажилласан байна. Цалингийн зардал 60,0 сая төгрөг, Нийгмийн даатгалын зардал 7,5 сая төгрөг, шуудан холбоо, интернэтийн зардал 3,0 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал 10,3 сая төгрөгийн тус тус хэмнэлттэй ажиллаж батлагдсан төсөвт зардлын 10,8 хувийн дүнд хэмнэлттэй ажилласан байна.</p>
4	<p>3.4.Төрийн албаны тухай хуулийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, төрийн жинхэнэ албыг тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллуулах, төрийн албанд мерит тогтолцоог тууштай хэрэгжүүлнэ.</p>	<p>Төрийн албаны тухай хуулийг хэрэгжилтийг ханган мерит тогтолцоог хэрэгжүүлэн ажиллах үүднээс 2 сул орон тоонд Төрийн албаны тухай хууль, Албан тушаалын тодорхойлолтод нийцүүлэн чадахуйн зарчимд тулгуурлан 2 албан хаагчийг түр орлон гүйцэтгэгчээр томилосон. Бусад сул болон эзгүй орон тоонд Төрийн албаны тухай хуулийн 42,43 дугаар зүйлд заасны дагуу албан тушаалын тодорхойлолтод нийцсэн, төрийн албаны нөөцөд бүртгэлтэй иргэдээс түр орлон гүйцэтгэгчээр томилон ажиллаж байна. Газарт үүссэн Төрийн захиргааны удирдах албан тушаалын 5, гүйцэтгэх албан тушаалын 9 сул орон тоонд тусгай шалгалт зарлуулах захиалгыг 2021 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 02/476, 11 дүгээр сарын 16-ны 2/2108 дугаар албан бичгээр Төрийн Албаны зөвлөлийн Нийслэл дэх салбар зөвлөлд хүргүүлсэн хэдий ч одоогоор тусгай шалгалт зарлагдаж, сул орон тоо нөхөгдөөгүй 14 ажлын байранд түр орлон гүйцэтгэгч ажиллаж байна.</p>
5	<p>3.5.Төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, шуурхай, чирэгдэлгүй байх нөхцөлийг бүрдүүлэн, үр дүнг нэмэгдүүлнэ.</p>	<p>Тендер шалгаруулалтад хүний оролцоог багасгаж олон нийтэд ил тод мэдээлэх шалгуурын дагуу Сангийн яам, Татварын Ерөнхий газар, Авто тээврийн үндэсний төвийн лавлагааг <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> цахим системд холбосныг үйл ажиллагаандаа ашиглаж байна. 2021 оны 04 дүгээр сарын 23-ны өдрөөс эхлэн Төрийн худалдан авах ажиллагааны газар болон Шүүхийн төрөлжсөн архив хамтран "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.4</p>

		<p>дэх заалтад хамаарах тендерт оролцогчдын иргэний хэргийн шүүхэд хариуцагчаар оролцож байсан эсэх тухай тодорхойлолтыг цахим хэлбэрт шилжүүлж, Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> цахим системээс авч ашиглах боломжтой болсон. Тус газраас зарлагдаж буй тендерийн баримт бичигт энэ талаар тусган, цахим тодорхойлолтуудыг үнэлгээнд 100% ашиглаж байгаа бөгөөд 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар нийт 345 төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг зарласнаас 300 төсөл, арга хэмжээний нийлүүлэгч болон гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан. “Тендер шалгаруулалтын материалыг төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр тухайн тендерт оролцогчдод ил болгох” журмын 2.2, 2.4-т заасны дагуу тухайн тендерт оролцогчдод төрийн худалдан авах ажиллагааны <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> цахим системээр дамжуулан ил болгон нийтэлж тендер шалгаруулалтад хяналт тавих боломжийг бүрдүүлсэн.</p> <p>Тендерт оролцогчдыг Сангийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 255 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журам”-ын 3.2.7. “Үнэлгээний хороо хуулийн 29.1-д заасан мэдэгдэл хүргүүлсэн өдөрт багтаан цахим системд тендер шалгаруулалтын үр дүнг үнэн зөв, бүрэн нийтэлж, шалгарсан тендерт оролцогчийн ирүүлсэн тендерийн нууцлаагүй хэсгийг Сангийн сайдын 2019 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 132 дугаар тушаалаар батлагдсан “Тендер шалгаруулалтын материалыг тухайн тендерт оролцогчдод ил болгох журам”-ын дагуу ил болгох.” гэж заасны дагуу мэдэгдэл хүргүүлсэн өдөрт багтаан Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд тендер шалгаруулалтын үр дүнг нийтлэхдээ тухайн байгууллагад хүргүүлж буй албан бичгийг хавсралтаар нэгэн зэрэг хүргүүлж хэвшсэн нь тендерт оролцогчдод чирэгдэл үүсгэлгүй цахим системээр мэдэгдлээ хүлээн авах, шалгараагүй оролцогчид шалгарсан оролцогчийн тендерийн материалтай танилцсанаар тендер шалгаруулалтын явцад хяналт тавих нөхцөл бүрэн бүрдсэн.</p>
6	3.6.Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг батлан, хэрэгжүүлнэ.	Төрийн албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангахад чиглэгдсэн дунд хугацааны хөтөлбөрийн хүрээнд 2021 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 9 заалт, 24 арга хэмжээг хэрэгжүүлэхээр боловсруулан газрын даргын 2021 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн А/07 дугаар тушаалын 1,2 дугаар хавсралтаар батлуулан, төлөвлөгөөний хэрэгжилт жилийн эцсийн байдлаар 94.2 хувийн гүйцэтгэлтэй байна.
7	3.7.Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн санал хүсэлт, өргөдөл гомдлыг хугацаанд нь шийдвэрлэн хариуг шуурхай өгч, хүнд суртал, чирэгдэлгүй зохион байгуулж, ахиц дэвшил гаргах арга хэмжээг авна.	2021 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн байдлаар тус газарт нийт 68 өргөдөл, гомдол ирүүлснийг <a href="http://www.egr.ulaanbaatar.mn">www.egr.ulaanbaatar.mn</a> цахим системийн өргөдөл, гомдлын модулыг ашиглан холбогдох албан хаагчид шилжүүлэн хуулийн хугацаанд шийдвэрлэн ажилласан. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 2 хоног 17 цаг 01 минут байна.
	3.8.Нийслэлийн Засаг дарга, Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас өгсөн үүргийг цаг алдалгүй шуурхай хэрэгжүүлж ажиллана.	Нийслэлийн удирдах ажилтнуудын ээлжит шуурхай зөвлөгөөнөөс өгсөн 40 удаагийн хурлын 136 үүрэг даалгаварын биелэлтийг нэгтгэн <a href="http://www.ulaanbaatar.mn">www.ulaanbaatar.mn</a> цахим хуудсаар дамжуулан тухай бүр тайлагнасан. Нийслэлийн Засаг даргын 18 захирамж, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралдааны 4 тэмдэглэлийн нийт 40 үүрэг даалгаврын биелэлтийг <a href="http://www.monitoring.ulaanbaatar.mn">www.monitoring.ulaanbaatar.mn</a> программд тухай бүр хоцролгүй тайлагнасан.
		НЗД-ын Зөвлөлийн хурлын 1 тэмдэглэлийн 3, Нийслэлийн Засаг даргын худалдан авах ажиллагаатай холбоотой 36 захирамжийн 228 заалтын хэрэгжилтийг нэгтгэн 2021 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн 2/186, 2021 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 2/721, 2021 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн 2/1803

8		<p>дугаар албан бичгээр тус тус НЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст хүргүүлсэн. Жилийн эцсийн биелэлтийг 2021 оны 12 дугаар сарын 25-ны өдөр хүргүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Улс, нийслэл, орон нутгийн төсвийн хөрөнгөөр нийслэлийн хэмжээнд зохион байгуулагдаж буй худалдан авах ажиллагааны явцын тайланг Сангийн сайдын 2018 оны 281 дүгээр тушаалаар батлагдсан маягт-3 дагуу боловсруулж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст сар бүрийн 05-ны өдрийн дотор нийт 10 удаа албан бичгээр болон ep.ulaanbaatar.mn нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын дундын мэдээллийн системээр тус тус хүргүүлсэн.</p> <p>Цаг үеийн холбогдолтой "Нэг хаалга-нэг шинжилгээ", Сонгинохайрхан дүүргийн 6 хорооны өрхийн эрүүл мэндийн төвд 29 албан хаагч батлагдсан хуваарийн дагуу дэмжлэг үзүүлэн ажилласан. Сайжруулсан түлшний хяналтад Сонгинохайрхан дүүргийн 2 хорооны сайжруулсан түлшний 6 цэгт 10 сард 1 удаа, 2 албан хаагч ажилласан. 12 дугаар сард сайжруулсан түлш борлуулах цэгүүдэд хяналтаар ажиллах албан хаагчдын хуваарийг гарган 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдрөөс ажиллаж эхэлсэн.</p>
9	<p>3.9.Энэхүү гэрээний хавсралт болох "Байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө"-нд тусгагдсан нийт арга хэмжээний биелэлтийг арга хэмжээ нэг бүрээр ханган, холбогдох журамд заасан хугацаанд тайлагнана.</p>	<p>Байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 2020 оны 12 дугаар сарын 25-ны өдөр батлуулсан бөгөөд 2021 оны 02 дугаар сарын 25-ны өдөр Нийслэлийн Засаг даргын Б/29 дугаар захирамжаар газрын дарга шинээр томилогдсон тул төлөвлөгөөг шинэчлэн баталж Төсвийн Ерөнхийлөн захирагчтай хариуцлагын гэрээг 2021 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр байгуулсан. Байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн эхний хагас жилийн тайланг 2021 оны 07 сарын 22-ны өдөр 02/900 дугаар албан бичгээр НЗДТГ-т хүргүүлсэн. Жилийн эцсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг 12 дугаар сарын 15-нд НЗДТГ-т хүргүүлсэн.</p>
10	<p>3.10.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны тухай хууль болон Шилэн дансны тухай хуульд заасан төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангаж, шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээ, мэдээллийн үнэн зөв байдлыг хариуцан ажиллана.</p>	<p>"Шилэн дансны тухай" хууль, "Шилэн дансны цахим хуудаст тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартын тогтоох тухай" журмын дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулж тайлант хугацаанд гэрээ байгуулагдсан 290 төсөл, арга хэмжээний холбогдох мэдээллийг маягтын дагуу хуулийн хугацаанд багтаан шилэн дансны системд мэдээлж ажилласан. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>-Хүний нөөц, бүтэц орон тооны мэдээллийг 11 удаа,</li> <li>-Газрын хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл мэдээллийг 11 удаа,</li> <li>-Санхүүтэй холбоотой сар, улирал, хагас жилээр болон тухай бүр мэдээлэх 88 мэдээллийг</li> <li>-Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга нараас хүлээн авсан 345 ширхэг "Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл"-ийг шилэн дансны системд цаг хугацааны хоцрогдолгүй тус тус нийтэлж ил тод байдлыг ханган ажилласан.</li> </ul>
11	<p>3.11.Монгол улсын Засгийн газрын 2017 оны "Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай" 01 дүгээр албан даалгавар, 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ыг тус тус хэрэгжүүлж ажиллана.</p>	<p>-Засгийн газрын 2017 оны "Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай" 01 дүгээр албан даалгаварын хүрээнд газрын албан хаагчдын өдөр бүрийн ажлын цагийн ирц, гадуур ажилласан тэмдэглэлд хяналт тавьж, иргэдэд чирэгдэлгүй, хүнд сурталгүй, ёс зүйн доголдолгүй үйлчилгээг үзүүлэхэд анхаарч, гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, байгууллагын хонгил, өрөө тасалгааны хамгаалалт, ажлын байрны эмх цэгцгийг сайжруулан, иргэд, албан хаагчдын аюулгүй байдлыг хангаж сахилга, хариуцлагатай ажилласан.</p> <p>-Засгийн газрын 2020 оны 206-р тогтоол болон НЗД-ын 335 дугаар захирамжийн дагуу "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>-Монгол Улсы Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тус байгууллага үндсэн хэрэгжүүлэх 1 зорилтын, 2 арга хэмжээний хагас жил, жилийн эцсийн хэрэгжилт,</li> <li>-Монгол Улсын хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 1, 3 дугаар улирал, эхний хагас жилийн биелэлт,</li> </ul>

		<p>-НЗД бөгөөд УБ хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хагас жил, 3 дугаар улирал, жилийн эцсийн биелэлт, -Нийслэлийн Засаг даргын 18 захирамж, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралдааны 4 тэмдэглэлийн нийт 40 үүрэг даалгаврын биелэлт болон газарт ирсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд, -Нийслэлийн удирдах ажилтнуудын ээлжит шуурхай зөвлөгөөн дээр Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчаас өгсөн 40 удаагийн хурлын 136 үүрэг даалгаврын хэрэгжилт, газрын удирдлагын зөвлөлийн 27 удаагийн хурлын 269 үүрэг даалгаврын хэрэгжилтэд тус тус хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ажилласан.</p>
--	--	---